



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/415

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


1. Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, нийгэм дэх тэдний оролцоог дэмжих зорилгоор зохион байгуулах гэж буй "Жангар фестиваль-2025" залуучуудын бүсийн нэгдсэн арга хэмжээнд хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах 100,000,000 (Нэг зуун сая) төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн батлагдсан зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг ажлын хэсэг (Аймгийн Засаг даргын орлогч)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

